



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 225

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 6.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөвсгөл аймгийн Прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 53,800,000.00 (тавин гурван сая найман зуун мянга) төгрөгийн балансын үнэ, 51,558,333.40 (тавин нэгэн сая таван зуун тавин найман мянга гурван зуун гучин гурван төгрөг дөчин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг хавсралтад заасны дагуу “Эрчист монгол” ХХК-нд балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Хөвсгөл аймгийн Прокурорын газрын Ерөнхий прокурор Ч.Алтансүх, “Эрчист монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Амартүвшин нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэл, тавар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132000684

10-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 15 дугаар сарын 28 ны/ний өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
"ЭРЧИСТ МОНГОЛ" ХХК-Д БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны нэр, төрөл	Үйлдвэрлэгд- сэн, ашиглалтад орсон огноо	Арлын дугаар	Улсын дугаар	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Renault DUSTER суудлын автомашин	7/28/2019	X7LHNSRHGN62927657	8736 ХӨҮ	53,800,000.00	51,558,333.40	2,241,666.60
НИЙТ ДҮН					53,800,000.00	51,558,333.40	2,241,666.60
					(тавин гурван сая найман зуун мянга)	(тавин нэгэн сая таван зуун тавин найман мянга гурван зуун гучин гурван төгрөг дөчин мөнгө)	(хоёр сая хоёр зуун дөчин нэгэн мянга зургаан зуун жаран зургаан төгрөг жаран мөнгө)